

**УЛААНБААТАР ХОТ, НАЛАЙХ ДҮҮРГИЙН 6-Р
ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ТЭНҮҮН
ХӨХИЙ” ХХК-ийн “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



2026 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ	3
1.1. Байгууллагын мэдээлэл	3
1.2. Талбайн байршил	3
1.2.2. Төслийн бүтэц зохион байгуулалт	4
Аялал жуулчлалын бааз төслийн барилга байгууламж	4
2.1. Байгаль орчны онцлог	5
2.2. Нийгэм эдийн засаг	5
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	7
3.1. Агаарын чанар	7
3.2. Хөрсөн бүрхэвч	7
3.3. Гадаргын болон газрын доорх ус	7
3.4. Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл	8
3.5. Ургамлан нөмрөг.....	8
3.5. Амьтны аймаг	8
3.7. Нийгэм эдийн засаг	8
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	9
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ.....	10
4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	11
4.3. Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө	11
4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	11
4.5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	12
4.6. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	13
4.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	15
ДҮГНЭЛТ	16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Талбайн байршлын зураг	3
Зураг 2. Аялал жуулчлалын баазын өнөөгийн байдал.....	4

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нутаг дэвсгэр засаг захиргааны нэгж.....	6
Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	9
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	10
Хүснэгт 4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	11
Хүснэгт 5. Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө	11
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	11
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	12
Хүснэгт 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	13
Хүснэгт 9. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....	14
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	15

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

1.1. Байгууллагын мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч: “Тэнүүн Хөхий” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9011782024
Регистрийн дугаар: 6378919
Хаяг: Улаанбаатар хот Налайх дүүрэг, 6-р хороо, Горхи-Тэрэлжийн БЦГ, Өвөр горхи Антын аманд байрлана.
Холбоо барих утас: 91919699


1.2. Төслийн онцлог, давуу талууд

Төслийн хүрээнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор дэд бүтцийн шийдлүүдийг байгаль орчинд ээлтэй байдлаар шийдсэн. Үүнд, 12 ширхэг мини хаус болон 3 Монгол гэрт зориулсан нийт гурван цэвэрлэх байгууламжийг тус тус суурилуулсан бөгөөд энэ нь хөрс, усны бохирдлоос сэргийлэхэд чухал хувь нэмэр оруулж байна. Ийнхүү нүхэн жорлонг ашиглаагүй нь уг төслийн гол давуу талуудын нэг юм.

Мөн төсөл нь аюулгүй байдлыг хангах зорилгоор камержуулалтын нэгдсэн системийг ашиглаж байгаа нь оршин суугчдын амар тайван байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд гадна орчны гэрэлтүүлэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох нарны эрчим хүчийг ашигладаг байна.

1.3. Талбайн байршил

“Тэнүүн Хөхий” ХХК-ийн “Аялал жуулчлалын бааз” төсөл нь Улаанбаатар хот Налайх дүүргийн Горхи-Тэрэлж БЦГ-ын Өвөр горхи, Антын ам нэрт газарт 30678.3 м² талбайг аялагч зөвшөөрөл бүхий хүн түр буудаллах, отоглох, ажиглалт судалгаа шинжилгээ хийх зориулалттай орон байр барих, ашиглах зориулалтаар газар ашиглах эрхийн гэрчилгээ авсан байна.



Зураг 1. Талбайн байршлын зураг

1.4. Төслийн бүтэц зохион байгуулалт

Аялал жуулчлалын бааз төслийн барилга байгууламж

Тус аялал жуулчлалын бааз нь нэг ээлжиндээ 50–60 хүртэлх амрагч хүлээн авах хүчин чадалтайгаар зохион байгуулагдсан бөгөөд ая тухтай амралтын нөхцөл, аюулгүй байдлыг бүрдүүлэх зорилгоор олон төрлийн дэд бүтцийн байгууламжуудыг цогц байдлаар төлөвлөн байгуулсан байна.

Үндсэн барилга байгууламжууд нь дараах бүтэцтэй:


- Амрагч хүлээн авах зориулалттай мини хаус 12 ширхэг
- Монгол гэр 7 ширхэг
- Нийтийн ашиглалтын боловсон ариун цэврийн өрөө
- Хүүхдийн тоглоомын талбай
- 2 ширхэг тухлан суух зориулалтын сүүдрэвч (саравч)
- Хөл бөмбөгийн талбай
- Узель (инженерийн шугам сүлжээний төв) – 1
- Авто зогсоол зэрэг нийтлэг үйлчилгээний талбай, байгууламжууд

Тус бааз нь гэр амралт болон мини хаус амралтыг хослуулсан загвараар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд зочдын амрах таатай орчныг бүрдүүлэхийн зэрэгцээ гэр бүл, хүүхэд багачуудын чөлөөт цагаа аюулгүй, хөгжилтэй өнгөрүүлэх нөхцөлийг бүрэн хангасан.

Инженерийн шийдлүүдийн хувьд:

- Гэр болон хаус амралтын байруудын халаалтыг бүрэн цахилгаан халаагуурын системээр шийдвэрлэсэн.
- Ахуйн хатуу хог хаягдлыг 14 хоног тутамд тогтмол ачиж, Налайх дүүргийн албан ёсны нэгдсэн хогийн цэг рүү тээвэрлэн зайлуулдаг.
- Шингэн хаягдлын хувьд цэвэрлэх байгууламжаар дамжуулан боловсруулдаг бөгөөд:
 - Дулааны улиралд саарал усыг ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж, усны хэмнэлттэй, байгальд ээлтэй шийдлийг хэрэгжүүлдэг.
 - Харин өвлийн улиралд боловсруулсан усыг стандартын дагуу шингээлтийн худгаар дамжуулан хөрсөнд шингээж, байгаль орчинд сөрөг нөлөө үүсгэхгүй байхаар зохион байгуулсан.

Эдгээр шийдлүүд нь тус аялал жуулчлалын баазыг зочдын тав тух, аюулгүй байдал, байгаль орчны хамгааллыг хослуулсан стандартыг хангасан, байгаль орчинд ээлтэй төсөл болгон хэрэгжүүлж байна.



Зураг 2. Аялал жуулчлалын баазын өнөөгийн байдал

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Байгаль орчны онцлог

“Тэнүүн Хөхий” ХХК нь Налайх дүүргийн Горхи-Тэрэлж БЦГ-ын Өвөр горхи, Антын ам нэрт газарт “Аялал жуулчлалын бааз” төслийг 30678.3 м² талбайд хэрэгжүүлж байна. Далайн түвшнээс дээш 1460-1463 метрийн үнэмлэхүй өндөрт, 5.6-11° налуужилттай талбайд байрлана.

Улаанбаатар хот нь уур амьсгалын хувьд чийглэгдүү, сэрүүн, нэн хүйтэн мужид хамаарагддаг. Энд өвөл нь харьцангуй хүйтэн, цасархаг, зун нь сэрүүн чийглэг, хур тунадас элбэгтэй (250-350 мм), салхи багатай байдаг. Энд намар эрт сэрүүсч, хавар хожуу дулаарч, цасан бүрхүүл хамгийн удаан хадгалагддаг.

Монгол орны агаарын дулаан, хүйтэн жилийн дотор тэгш хэмтэй явцтай байдаг. Улаанбаатар хотын агаарын температур ОЖД-аар 1-3 градусын хооронд хэлбэлздэг байна. Хамгийн хүйтэн 1 дүгээр сард агаарын дундаж температур -18 градусаас -23 градус байдаг. Хамгийн дулаан 7 дугаар сард агаарын температур 20-21.4 градус байна. Жилдээ салхигүй өдөр 100 орчим байх бөгөөд салхины хурд 4-6 м/с, баруун хойд зүгийн салхи голлоно. Өвөл салхи багатай, хавар салхи ихтэй байдаг.

2.2. Нийгэм эдийн засаг

1922 оны 12 дугаар сарын 25-нд Налайхын уурхай улсын үйлдвэр болсон. 1932 он хүртэл Налайхын уурхай улирлын чанартай үйл ажиллагаагаа явуулж байгаад 1932 онд 60 квт, 1936 онд 120 квт -ын хүчин чадалтай цахилгаан станцтай болж 1930-аад он хүртэл чулуун нүүрсийг ард иргэд, албан байгууллага зохих хэмжээгээр хэрэглэж байсан бол 1930-аад оноос эхлэн эх орны нийслэлд аж үйлдвэрийн газрууд шинээр байгуулагдаж 1939 оны 2 дугаар сарын 26-нд анхны төв цахилгаан станцыг 2500 квт-ын хүч чадалтайгаар ашиглалтанд оруулсан нь түлшний хэрэгцээний шаардлага улам өсөж, үүнтэй уялдан Налайхын уурхайг өргөтгөх арга хэмжээнүүдийг авсан байна. Сүүлд техник технологийн шинэчлэл хийж 1954-1958 онуудад Налайхын их уурхайг барьж байгуулсан байна. Их уурхай нь жилдээ 600 мянган тн нүүрс гаргах хүчин чадалтай, 100 хувь механикжсан, 1500 гаруй ажилтантай, улсын аж үйлдвэржилтэд шаардлагатай нүүрсний хэрэгцээний 70 хувийг дангаараа хангаж ирсэн түүхэн үүрэг гүйцэтгэжээ.

1962 оны 5 сарын 10-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 88-р зарлигаар Налайхын уурхайн төвийг Налайх хот болгон, хороо захиргаа хотын захиргаа болгон өөрчилж байв. 1962 оны 12 сарын 6-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 202 дугаар зарлигаар Налайх хотод харьяалуулан Хонхор, Горхийн хороо захиргаадыг тус тус байгуулсан. 1965 оны 12 сарын 9-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 250 дугаар зарлигаар Налайх хотыг район эрхтэйгээр Улаанбаатар хотод харьяалуулж Налайх хотын харьяаны Хонхор, Горхийн хороодыг татан буулгасан улмаар Улаанбаатар хотын Уурхайчдын хороо, Налайх хот, Налайх район зэрэг засаг, захиргааны нэгж болон нэрлэгдэж байгаад 1992 оны оны 8 дугаар сарын 18-ны өдрийн шинэ Үндсэн хуулиар Нийслэлийн Налайх дүүрэг статустай болсон байна.

Налайх дүүрэг нь Нийслэлийн есөн дүүргийн нэг бөгөөд нийслэлээс зүүн урагш 36 км-т өвөлдөө -20°C-25°C, зундаа +23°C +26°C-ийн дундаж температуртай ойт хээрийн бүсэд оршдог.

Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумтай хиллэдэг, 68.7 мянган га нутаг дэвсгэрийг эзлэн оршдог. Засаг захиргааны 8 хороотой. 5 болон 6 дугаар хороод нь жуулчдыг татдаг байгалийн үзэсгэлэнт газар болох Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт байрладаг.

Хүснэгт 1. Нутаг дэвсгэр засаг захиргааны нэгж

Хороо	Нутаг дэвсгэрийн хэмжээ мян. км ²
1-р хороо	60.9
2-р хороо	0.4
3-р хороо	185.5
4-р хороо	10.8
5-р хороо	172.8
6-р хороо	252.3
7-р хороо	3.1
8-р хороо	1.7
Нийт дүн	687.6

Хүн амын нягтралаар авч үзвэл Налайх дүүргийн нэг км² нутаг дэвсгэрт 2015 онд 52 хүн оршин сууж байсан бол 2016 онд 53 хүн, 2017 онд 54 хүн, 2018 онд 54 хүн, 2019 онд 54.8 хүн, 2020 онд 56.2 хүн, 2021 онд 56.6 хүн, 2022 онд 57.5 хүн оршин сууж байна.

Хоймортоо Майхан уулаа залж, Хатан тунамал Туул гол, Тэрэлжийн голоо зүмбэрлүүлэн, түүх домогт Чингис уул, Суварга хайрханаа дээдлэн шүтэж, Зуун ламын агуй, Арьяабалын сүм хийд, Мэлхий хад, Бүс нуур, Элстэйн зуун мод бүхий үзэсгэлэнт сайхан Налайх нутаг өдгөө ч үйлдвэржилт эрчимтэй хөгжиж буй хот хэвээр байна.

Монгол Улсын авто замын босоо болон хэвтээ тэнхлэгийн огтлолцолд оршдог, авто зам, төмөр зам, агаарын тээвэр хөгжсөн, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй, нийслэлийг цэвэр усаар хангаж байгаа дээд эх үүсвэртэй шууд холбогдсон, Монгол орны аялал жуулчлалын гол бүс нутаг хамаардаг, хүн амын дийлэнх олонхийг залуучууд болон хөдөлмөрийн насныхан эзэлдэг, түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт ихтэй зэрэг давуу тал олон.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Агаарын чанар

- Тээврийн хэрэгслийн дуу чимээ, шуугиан орчны дуу чимээг нэмэгдүүлэх,
- Тээврийн хэрэгслээс ялгарах хийн хаягдлаар агаар орчин бохирдох,
- Тээврийн хэрэгслээс тоосжилт үүсэх,

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Төсөлд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийн хорт хий ялгаруулалтыг MNS 5014:2009 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд нь барьж ажиллах, шаардлагатай бол утааны шүүлтүүр суурилуулах, галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох,
- Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлж тоос болон бусад бохирдуулагч бодисын хэмжилтийг тогтмол хугацаанд хийж, агаарын бохирдолтыг хянах, MNS 4585:2016 стандартын ЗДХ-с давсан агууламж илэрсэн тохиолдолд тухай бүрт эх үүсвэрийг тогтоон бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Хог хаягдлыг хаях зориулалтын дагуу байхаар зохион байгуулах,
- Хэт халалт, агаарын бохирдол тоосжилтыг цаашид бага байлгахын тулд ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх,

3.2. Хөрсөн бүрхэвч

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Барилгажилт, ахуйн хог хаягдлын нөлөөгөөр талбайн өнгөн хөрс бохирдох,
- Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Хөрсөнд бохирдол нэвчихгүй байдлаар төлөвлөх,
- Хөрс бохирдохоос сэргийлэх, хатуу хог хаягдлыг эрүүл ахуйн нөхцөлийг хангасан цэгт 3-с доошгүй ангилан ялгаж түр хадгалан, зөөвөрлөж тогтоосон цэгт зайлуулж байх,
- Бусад хог хаягдал болон бусад шингэн хаягдлыг хур борооны усаар зөөгдөхгүй байхаар төлөвлөх,
- Автомашины зогсоол, засварын талбайг хатуу хучилттай болгох,
- Одоо ашиглагдаж буй явган хүний замуудыг тохижуулж ердийн хөрсөн зам ашиглахаас зайлсхийх,
- Тухайн талбайд хүнд элементийн бохирдол илрээгүй боловч цаашдын үйл ажиллагааны үед санаатай болон санамсаргүй байдлаар хөрсийг бохирдуулж болзошгүй. Хэрэв бохирдсон тохиолдолд нарийвчилсан судалгаа хийж бохирдлыг бууруулах, саармагжуулах арга замуудыг хэрэгжүүлэх,
- Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэж, аливаа газар ашиглалтын зөрчил илэрсэн тухай бүрд зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3. Гадаргын болон газрын доорх ус

- Шингэн хаягдал зайлуулах шугамын бүтэн байдал алдагдсанаас хөрсөөр дамжин гүний усыг бохирдуулах
- Хог хаягдлыг ил задгай хаяснаар хөрсөөр дамжин гүний ус нянгийн бохирдолтод өртөх

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ундны усанд усны чанарын химийн шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор хийлгэж, MNS 0900:2018 стандартын шаардлагад нийцүүлэн ажиллаж,
- Төслийн хэмжээнд нийт ус ашиглалтад “Усны тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 30.1 дахь хэсгүүдийг хэрэгжүүлж ажиллах,
- Ундны усыг хадгалах, нөөцлөх, хэмнэлттэй зарцуулах, усны бохирдлыг бууруулах боломжийг бүрдүүлж, эдгээр үйл ажиллагаанд тохируулсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

3.4. Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Ажилчдад хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаж байх. Байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хугацаанд хамрагдуулж байх
- Эрүүл ахуй аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг өдөр бүр өгч байх
- Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон зориулалтын ажлын хувцсаар хангах
- Галын аюулгүй ажиллагаа болон гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах
- Ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахин мөрдүүлэх тал дээр хяналт тавих

3.5. Ургамлан нөмрөг

Төсөл хэрэгжүүлэгч нь төслөөс үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах болон ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тохижилтийн ажлын хүрээнд эзэмшил талбайн 20 хувьд ногоон байгууламж, тарималжуулалтын ажил хийх шаардлагатай байна.

3.5. Амьтны аймаг

Төслийн талбайн нь хүн ам суурьшлын бүсэд байрлалтай тул амьтад үргэж, дайжсан байдалтай байна.

- Ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаяснаас амьтад муудсан хүнсийг идэж өвчлөх, үрэгдэх

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

Төслийн талбай, түүний орчимд амьдардаг амьтдыг агнах, үргээх зэрэг санаатай үйлдэл гаргахаас сэргийлж байгууллагын дотоод журамд энэ талаар заалт тусган тогтмол зөвлөмж, анхааруулга өгч байх, шаардлагагүй нөхцөлд машин техникээс хүчтэй дуу чимээ гаргахгүй байхыг анхааруулах шаардлагатай.

3.7. Нийгэм эдийн засаг

- Иргэдийн амьдрах орчны тав тух алдагдахаас сэргийлж шөнийн цагаар 45 дБа илүү дуу чимээ гаргасан үйл ажиллагаа явуулахгүй байх,
- Ажилчдыг эрүүл шим тэжээллэг хоол хүнсээр хангах,
- Аюулгүй байдлыг хангах хувцас хэрэглэлээр тогтмол хангаж, хэрэглүүлэн, зөв хэрэглээний талаар дадлагыг тогтмол хийх,
- Үйл ажиллагааг зохих стандарт, хууль, журамд нийцүүлэн чанартай хийж гүйцэтгэн гэнэтийн аливаа эрсдэл үүсэхээс сэргийлэх, бэлэн байдалд үйл ажиллагааг явуулах,

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээсэн.

Иймд 2026 онд мэргэжлийн эрх бүхий “Маргад Очирваань” ХХК-иар боловсруулсан менежментийн төлөвлөгөөний дагуу 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, хянан батлах журмыг баримтлан боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2026 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 1,028,500 төг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Зардлын хэлбэр	2026 он
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	150,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	50,000
Ногоон байгууламжийн төлөвлөгөөний зардал	200,000
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	460,000
Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	-
Орчны хяналт шинжилгээний зардал	168,500
НИЙТ	1,028,500

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Тээврийн хэрэгслээс ялгарах хийн хаягдал	Тоосжилт үүсэхээс сэргийлж зам талбайд засвар үйлчилгээ хийх	Зогсоолын хэсэг	ш	-	150.0		Төслийн хугацаанд	“Агаарын тухай хууль” “Агаар бохирдлын төлбөрийн тухай хууль” MNS 4585:2016 Авто тээврийн тухай хууль MNS 6278:2011 MNS 4597:2014 MNS 6056:2009 MNS 5973:2009 MNS 4598:2020
УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Ахуйн хэрэглээний ус	Ус ашигласны төлбөр тогтмол хугацаанд төлөх	Төслийн хэмжээнд	Удаа	12	Үйл ажиллагааны зардалаар		Төслийн хугацаанд	“Усны тухай хууль” MNS 0899:2020 MNS 0900:2018 MNS 6561:2015
ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Ил задгай хог хаяснаар агаар орчин бохирдох, борооны усаар хөрсөнд нэвчиж газрын доорх ус, хөрсний чанарыг муутгах, халдварт өвчин үүсгэх	Төсөл хэрэгжих талбай, хашаанаас гадна хог хаягдал хаяхгүй, газрын гадарга, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж байх	Ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвч	тогтмол	тогтмол	Үйл ажиллагааны зардалаар		Төслийн хугацаанд	MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт MNS 5924:2015 Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага
УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БЦГ-ЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТЭНҮҮН ХӨХИЙ” ХХК-ИЙН “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайн ойр орчим бохирдох, ургамлан нөмрөг талхлагдах	Төслийн талбайн ойр орчмын цэвэрлэгээг тогтмол хийх	Талбайн ойр орчим	Удаа	Улирал бүр	Үйл ажиллагааны зардлаар	Төслийн хугацаанд	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч эрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Ургамал хамгааллын тухай хууль MNS 5918:2023
НИЙТ					150,000		

4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Үйл ажиллагааны арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
MNS 6426:2013 стандартын 5.1.8 “Эдэлбэр газрын нийт талбайн 20-с багагүй хувьд ногоон байгууламж тарималжуулалт хийх” шаардлагын дагуу ногоон байгууламж тарих	Суулгац тарихад шаардлагатай материал, хар шороо, бордоо авах	Ой, ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвч, агаарын чанар	кг	10	50.0	50.0	2026 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч эрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд	Шилмүүст мод		ш	15	10.0	150.0	2026 он	
Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн нийт зардал						200.0		

4.3. Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Хүснэгт 5. Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагаа хэрэгжүүлэх хугацаа	Зардал, мян.төг	Хариуцах байгууллага
1	Орон нутгаас зохион байгуулж буй нэгдсэн цэвэрлэгээ, үйл ажиллагаанд тогтмол идэвхтэй хамрагдах	Нийгмийн хариуцлага, оролцоо нэмэгдэх	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч
2	Шинээр ажлын байр бий болох тохиолдолд орон нутгийн иргэдийг авч, ажиллуулах	Ажилгүйдлийн тоо буурах, хөдөлмөрийн ур чадвар нэмэгдэх	Төсөл хэрэгжих хугацаанд	Хүний нөөцийн дотоод зохион байгуулалтад тусгах	
НИЙТ					-

4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БЦГ-ЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТЭНҮҮН ХӨХИЙ” ХХК-ИЙН “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын төрөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хугацаа (2026 он)	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Ахуйн хатуу хог хаягдал	Хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой байх, хаягжуулах	Ахуйн хог хаягдлын менежмент	Төсөл хэрэгжих хугацаанд	50.0	50.0	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2011 БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаалаар батлагдсан “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам” Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар 10.2.3, 10.2.4, 11 дүгээр 11.1, 11.2
	Эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайн цэвэрлэгээг хийх	Төслийн хэмжээнд	Тогтмол	Үйл ажиллагааны зардалаар		
	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлж ойр орчмыг тогтмол цэвэрлэж байх	Хатуу хог хаягдлын цэгт	Тухай бүр	Үйл ажиллагааны зардалаар		
	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Төслийн хүрээнд	Тухай бүрд нь	Зардал тусгах шаардлагагүй		
Ахуйн шингэн хог хаягдал	Цэвэрлэх байгууламжаас гарсан лагыг соруулж зайлуулах	Төслийн хэмжээнд	Жилд 1 удаа	Гэрээний дүнгээр		
НИЙТ				50,000		

4.5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Тэнүүн Хөхий” ХХК-ийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Төслийн үйл ажиллагаанаас хөрс, ус, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх, нөлөөллийг бууруулах, сааруулах үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх, төлөвлөхийн тулд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэх боломжтой бохирдлын эх үүсвэрүүд дээр тогтмол мониторингийн хэмжилт хийх шаардлагатай. Мөн цаашид тус төслийн үйл ажиллагаа болон ашиглалтын талбайн хэмжээ нэмэгдэхээр бол хяналт, мониторингийн цэгүүд нэмэгдэх боломжтой.

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил		Хугацаа ба давтамж	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт
1. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
1.1	- Хаягдал усны шинжилгээ	1 мл-т илрүүлэх 100 мл-т	Технологийн хаягдал ус	Нийт 1 цэгт	Жилд 1 удаа	68.5	68.5*1 цэг*1 удаа= 68.5	Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори	MNS (ISO) 5667-1:2002 MNS (ISO) 5667-2:2002 MNS 0900:2018
2. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БЦГ-ЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТЭНҮҮН ХӨХИЙ” ХХК-ИЙН “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1.	- Хөрсний хүнд элементүүд /Pb, Cr, Cd, Ni, Co, Cu/	мг/кг	Төслийн талбайд	Нийт 1 цэгт	Жилд 1 удаа /Намар/	25.0	25.0*2 дээж*1 удаа = 50.0	Хөрс, ус судлалын лаборатори	MNS 3298-90 MNS 2305:94 MNS 5850-2023 MNS 3310-91
2.2.	- Хөрсний агрохимийн үндсэн үзүүлэлтүүд	мг/кг	Байгалийн хөрс /хяналтын цэг/			20.0	25.0*2 дээж*1 удаа = 50.0		
1 жилийн ОХШХ-ийн нийт зардал							168,500 төгрөг		

4.6. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нэг жилийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ									
1	Гамшиг	Ажилчдын дунд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх болон гамшгийн үеийн авран хамгаалах сургалт зохион байгуулах, мэдээллийн самбар байршуулах	Нийт ажилчид	Жилд 2 удаа	Үйл ажиллагааны зардлаар		10 сард	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, МУ-ын Шадар сайдын 120 тоот тушаал, 2018.12.07	
2		Гамшгийн үед ажиллах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө	-*-	Үйл ажиллагааны зардал		4-р улиралд		
3	Хүчтэй шороон болон цасан шуурга	Хог хаягдал хийсэхгүй байх нөхцөлийг хангасан хогийн төвлөрсөн цэгийг байгуулах	Хогийн цэг	1	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан			Хог хаягдлын тухай хууль	
4		Дуу цахилгаантай бороо орох үед ажилчид, техник хэрэгслийн үйл ажиллагааг түр зогсоох зэрэг эрсдэлийн үед өөрийгөө хамгаалах талаар сургалт зохион байгуулах	Нийт ажилчид	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардлаар		Төсөл хэрэгжүүлэхээс өмнө	Гамшгийн тухай хууль	
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙ									
5	Ажилчид бэртэх	Ажилчдын ажлын байрны нөхцөлтэй нь уялдуулан аюулгүй ажиллагааны, хувцас, хамгаалах хэрэгслээр хангах	Нийт ажилчид	-*-	Үйл ажиллагааны зардлаар		Жилд 1 удаа	ХАБЭА-н бодлого, заавар журам, стандарт, Хөдөлмөрийн тухай	
		Жилд 1 удаа							

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БЦГ-ЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТЭНҮҮН ХӨХИЙ” ХХК-ИЙН “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Дархлаа дэмжих, хор саармагжуулах эрүүл ахуйн шаардлагатай бүтээгдэхүүнээр хангах					Өдөр бүр	хууль, Эрүүл мэндийн тухай хууль	
6	Гал түймэр	Гал гарч болзошгүй объектуудын ойролцоо ил гал гаргах, тамхи татахыг хатуу хориглох, хянах	Ажилчдын байр, агуулахын гадна	-*-	-			2026 онд өдөр тутамд	Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, журам, галын аюулгүй байдлын тухай хууль
		Болзошгүй галын аюулын үед ашиглах гал унтраах хэрэгсэл, материалыг шаардлагатай газар бэлэн байлгах, хугацаа дууссан тухай бүр шинэчлэх		2 иж бүрдэл	50.0	100.0	100.0	2026 он	
		Галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай төлөвлөгөө, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж аймгийн онцгой байдлын албаар батлуулах	2 ш	Галын хор цэнэглэх-30.0	60.0	60.0	2026 он		
		Галын аюулгүй байдлын дүгнэлтийг онцгой байдлын газраар гаргуулах	Ажилчид, төслийн талбай	-*-	Зардал шаардахгүй			Төсөл хэрэгжүүлэхээс өмнө	
		Ажилчдад галын аюулын үед авах арга хэмжээний талаарх сургалтыг явуулах	Аялал жуулчлалын бааз	1	200.0	200.0	200.0	Жилд	
		Ажилчдад галын аюулын үед авах арга хэмжээний талаарх сургалтыг явуулах	Нийт ажилчид	-*-	ХАБЭА-н сургалт, сурталчилгааны зардлаар			2-р улиралд	
Нийт зардал							460,000		

4.7. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 9. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх	Төслийн хэмжээнд	Удаа/жилд	1	Хариуцсан ажилтан		Жил бүрийн 12.20 дотор	Байгаль хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль БОАЖ-ын сайдын 2019.10.29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан
Ус ашигласны төлбөр	Усны нөөц Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Сар бүр	1 жилд 12 удаа	Ус ашиглуулах гэрээний дүнгээр, тоолуурын заалтаар		2026 он	
Хүрээлэн буй орчноо хамгаалах, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж бүхий сургалт зохион байгуулах	Экосистем, эрүүл ахуй, ёс зүй	Удаа/жилд	1	Дотоод үйл ажиллагааны хүрээнд	2026 онд	2026 он	

							батлах, тайлагнах журам” Усны тухай хууль
НИЙТ						-	

4.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцаж зохион байгуулах албан тушаалтан
1	Нийслэлийн байгаль орчны газраар хянуулж БОУАӨЯ-аар батлуулах	www.eic.mn цахим хэлбэрээр	Тухайн жилийн БОМТ-ийн биелэлтийн тайлан	Жил бүрийн 11-р сарын 1-ний дотор	Үйл ажиллагааны зардал	Удирдлага Ерөнхий инженер Хариуцсан ажилтан
2	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам -Асуудал хариуцсан мэргэжилтэн -БО хяналтын байцаагч	Хуралд танилцуулах, Уулзалт зохион байгуулах	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 1-ний дотор		
3	Орон нутгийн иргэд					
4	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Тайлан, төлөвлөгөөг www.eic.mn цахим хэлбэрээр	Төлөвлөгөөг хянуулан батлуулах	12-р сарын 20-ний дотор		

ДҮГНЭЛТ

“Тэнүүн Хөхий” ХХК нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн Горхи-Тэрэлж БЦГ-ын Өвөр горхи, Антын ам нэрт газарт дэвсгэрт “Аялал жуулчлалын бааз” төсөл үйл ажиллагаагаа явуулж байна. Төслийн хүрээнд 2026 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд **1,028,500 төгрөг** ба үүнд 2026 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа зэрэг ажлын зардлууд багтсан болно.